БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

## БАЯН-АГТ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

**Аудитын код: БУА-2023/129/НА-СТА-ТШЗ**


Цахим хуудас: www.audit.mn

Булган аймаг

2023 он

Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ
Утас: 70342580 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn

Аудитын менежер: Ж.Энхцоодол
Утас: 70342716 Цахим хаяг: enkhtsoodolj@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн:
Баталгаат тооцоолол аудит ХХК
Захирал: М.Буянбулган
Утас: 77153069 Цахим хаяг: buyanbulgan@batalgaattaudit.com


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ....3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ....5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА....12
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа....12
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин....12
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа....13
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа....13
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа....14
4. АУДИТЫН ТАЙЛАН....14
4.1 Ерөнхий зүйл....14
4.2 Материаллаг байдал....15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт....15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал 15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт....15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт....16
4.5.1 Завсрын аудитын талаар....16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал....16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ....16
5.1 Төлбөрийн акт....16
5.2 Албан шаардлага....16
5.3 Зөвлөмж....16
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ....17

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ИТХ | Иргэдийн төлөөлөгчдийн хурал |
| НББ | Нягтлан бодох бүртгэл |
| НББББББ | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |

БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс:7034-2580
E-mail:bulgan@audit.gov.mn

2023.02.24 № 127

танай________________ны №________________т

БАЯН-АГТ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТӨВИЙН ДАРГА Б.ХУЛАН ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баян-Агт сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын Гурвын 6, Зургаагийн 4 заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн хуулийн 5.1.4, 13.1, 13.6, 19.1, 20.1.4, 20.2.4 заалтуудыг тус тус хэрэгжүүлээгүйтэй холбоотой зөрчлүүд илэрч тээвэр шатахуунд зарцуулснаар тайлагнасан 25,495.7 мянган төгрөгийг баталгаажуулах боломжгүйд хүргэж, бидний тогтоосон 2,879.4 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс давсан нь санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Асуудлыг онцолсон хэсэг**

2022 онд улсын төсвөөс 627,430.1 мянган, орон нутгийн төсвөөс 55,374.5 мянган, нэмэлтээр 35.0 мянган нийт 682839,6 төгрөгийн санхүүжилт авсан нь

D:/bichighereg/2023A4toot

006020147

..

өнгөрсөн оноос 139,502,6 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны 178,635.8 мянган төгрөгийн авлагатай холбоотой байна.

"Нүүдлийн амбулатори"-ийн тусламж үйлчилгээ, эрт илрүүлэг үзлэг зохион байгуулсан. Сүрьеэгүй сум болох, магадлан итгэмжлэл орж, амбулаторийн 2 дугаар байранд урсгал засвар хийж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангагдсан.

**Аудитын гол асуудал**

Баян-агт сумын эрүүл мэндийн төв нь 2022 онд аймгийн Эрүүл мэндийн газар болон Засаг даргатай Гүйцэтгэлийн төлөвлөгөөг 5 зорилтын хүрээнд 31 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, батлуулсныг 96 хувийн биелэлтэйгээр тайлагнасан. 2021 онд төсвийн санхүүжилтийн дутуу 183,271.1 мянган төгрөгийн авлагатай байсан.

**Бусад асуудлын хэсэг**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.ЭРДЭНЭ

D:/bichighereg/2023A4toot

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **365,102,095.15** | **305,430,230.53** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 19,619,282.00 | 114,901,639.58 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 19,619,282.00 | 114,901,639.58 |
| **3121** | **Төгрөг** | 19,619,282.00 | 114,901,639.58 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 750,536.00 | 114,901,639.58 |
| 31215 | Нэмэлт санхүүжилтийн харилцах | 18,868,746.00 | 0.00 |
| **33** | **АВЛАГА** | 187,350,991.72 | 132,505.57 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 1,686,466.91 | 0.00 |
| **335** | **Бусад авлага** | 185,664,524.81 | 132,505.57 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 185,532,019.24 | 0.0 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 132,505.57 | 132,505.57 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 158,131,821.43 | 190,396,085.38 |
| **351** | **Түүхий эд материал** | 108,462,855.14 | 144,682,945.59 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 22,230,990.97 | 20,786,800.97 |
| 35130 | Эм боох материал | 86,231,864.17 | 123,896,144.62 |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | 0.00 | 139,600.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 48,523,966.29 | 44,668,539.79 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 2,560,895.00 | 2,201,885.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 38,933,231.00 | 34,846,866.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 1,108,667.00 | 1,108,667.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 3,298.00 | 3,298.00 |
| 35460 | Хүнсний материал | 5,917,875.29 | 6,507,823.79 |
| 35600 | Мал амьтад | 1,145,000.00 | 905,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **594,298,042.90** | **733,469,637.39** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 594,298,042.90 | 733,469,637.39 |
| **392** | **Биет хөрөнгө** | 579,107,543.04 | 718,822,887.36 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 527,846,595.92 | 540,146,595.92 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (43,516,594.25) | (56,412,049.63) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 39,485,000.00 | 42,900,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (26,869,900.16) | (4,031,755.92) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 150,252,211.36 | 253,827,436.36 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (86,308,158.66) | (96,066,584.39) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 27,324,215.00 | 51,851,850.29 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (9,105,826.17) | (13,392,605.27) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 15,190,499.86 | 14,646,750.03 |
| 39301 | Програм хангамж | 2,000,000.00 | 1,600,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (1,137,500.14) | (1,281,249.97) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 14,328,000.00 | 14,328,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **959,400,138.05** | **1,038,899,867.92** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **353,070.00** | 0.00 |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 353,070.00 | 0.00 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 353,070.00 | 0.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **959,047,068.05** | **1,038,899,867.92** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 959,047,068.05 | 1,038,899,867.92 |

| | | | |
|---|---|---|---|
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 307,097,069.44 | 307,097,069.44 |
| 51101 | Өмч: - төрийн | 307,097,069.44 | 307,097,069.44 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 564,607,307.71 | 644,460,107.58 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 564,607,307.71 | 564,607,307.71 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 79,852,799.87 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 87,342,690.90 | 87,342,690.90 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **959,400,138.05** | **1,038,899,867.92** |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

Тайлант хугацаа: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,285,900,454.43** | **854,944,274.57** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **284,887,459.43** | **172,104,699.57** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 284,887,459.43 | 172,104,699.57 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан | 284,887,459.43 | 172,104,699.57 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,001,012,995.00** | **682,839,575.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 456,636,700.00 | 627,430,075.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 0.00 | 626,535,761.00 |
| 131005 | Хөрөнгийн санхүүжилт | 0.00 | 894,314.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 456,636,700.00 | 0.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 284,343,625.00 | 35,000.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 166,100.00 | 0.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 38,156,625.00 | 0.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 246,020,900.00 | 35,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 56,399,690.00 | 55,374,500.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 56,399,690.00 | 55,374,500.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 203,632,980.00 | 0.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 203,632,980.00 | 0.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **978,057,445.95** | **766,193,249.85** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **978,057,445.95** | **766,193,249.85** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 930,537,145.95 | 764,905,607.05 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 402,682,240.57 | 390,224,563.15 |
| 210101 | Үндсэн цалин | 286,737,395.57 | 254,409,242.60 |
| 210102 | Нэмэгдэл | 85,067,959.00 | 106,386,301.10 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 5,332,000.00 | 4,640,996.45 |
| 210104 | Урамшуулал | 25,544,886.00 | 24,788,023.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 50,461,612.78 | 47,597,075.58 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 37,234,105.54 | 34,645,121.48 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,524,344.72 | 3,401,602.92 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,795,675.45 | 2,684,322.30 |

| | | | |
|---|---|---|---|
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 860,963.95 | 685,677.85 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,046,523.12 | 6,180,351.03 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 52,437,090.00 | 52,086,857.20 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,607,145.00 | 2,531,312.20 |
| 210302 | Түлш, халаалт | 49,703,545.00 | 49,555,545.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 126,400.00 | 0.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 37,567,352.90 | 35,255,816.10 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,898,790.00 | 3,335,530.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 19,804,879.90 | 26,796,730.50 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,787,690.00 | 1,444,595.60 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 9,919,890.00 | 1,105,660.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,507,403.00 | 2,573,300.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 648,700.00 | 0.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 323,499,791.11 | 119,864,461.16 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 305,682,620.11 | 105,745,709.66 |
| 210502 | Хоол, хүнс | 17,535,171.00 | 11,387,751.50 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 282,000.00 | 2,731,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,847,333.49 | 41,476,865.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 80,000.00 | 697,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,767,333.49 | 40,779,865.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 2,158,400.00 | 3,896,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,158,400.00 | 3,896,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 5,179,378.00 | 5,914,377.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 4,891,474.00 | 5,129,977.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 0.00 | 72,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 58,000.00 | 57,600.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 119,820.00 | 120,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 0.00 | 49,300.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 0.00 | 445,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 40,500.00 | 40,500.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 69,584.00 | 0.0 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 54,703,947.10 | 68,589,591.86 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,061,208.00 | 23,789,120.91 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 52,642,739.10 | 44,800,470.95 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 47,520,300.00 | 1,287,642.80 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 47,520,300.00 | 0.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 33,800,000.00 | 0.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 13,720,300.00 | 0.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 0.00 | 1,287,642.80 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 0.00 | 1,287,642.80 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **307,843,008.48** | **88,751,024.72** |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 0.00 | 8,898,224.85 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | 0.00 | (8,898,224.85) |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **307,843,008.48** | **79,852,799.87** |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

Тайлант хугацаа: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **822,342,195.00** | **861,475,375.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | 0.00 | **178,635,800.00** |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 0.00 | 178,635,800.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **822,342,195.00** | **682,839,575.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 456,636,700.00 | 627,430,075.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 0.0 | 626,535,761.00 |
| 131005 | Хөрөнгийн санхүүжилт | 0.0 | 894,314.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 456,636,700.00 | 0.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 284,343,625.00 | 35,000.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 166,100.00 | 0.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 246,020,900.00 | 35,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 56,399,690.00 | 55,374,500.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 56,399,690.00 | 55,374,500.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 24,962,180.00 | 0.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 24,962,180.00 | 0.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **789,958,013.00** | **670,738,017.42** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **789,958,013.00** | **670,738,017.42** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **742,719,213.00** | **669,450,374.62** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 402,899,488.57 | 390,224,563.15 |
| 210101 | Үндсэн цалин | 268,577,814.57 | 254,409,242.60 |
| 210102 | Нэмэгдэл | 102,652,124.00 | 106,386,301.10 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 5,889,000.00 | 4,640,996.45 |
| 210104 | Урамшуулал | 25,780,550.00 | 24,788,023.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 52,171,705.69 | 45,910,608.67 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 38,548,330.80 | 32,958,654.57 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,488,874.70 | 3,401,602.92 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,780,479.79 | 2,684,322.30 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 667,141.66 | 685,677.85 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,686,878.74 | 6,180,351.03 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 52,249,690.00 | 52,086,857.20 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,594,145.00 | 2,531,312.20 |
| 210302 | Түлш, халаалт | 49,555,545.00 | 49,555,545.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 100,000.00 | 0.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 38,675,965.00 | 33,954,771.60 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,424,000.00 | 3,335,530.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 21,102,125.00 | 25,495,686.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,787,690.00 | 1,444,595.60 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 6,417,150.00 | 1,105,660.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,945,000.00 | 2,573,300.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 168,282,141.74 | 75,477,678.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 147,842,141.74 | 61,200,978.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210502 | Хоол, хүнс | 16,940,000.00 | 11,545,700.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 3,500,000.00 | 2,731,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 13,025,100.00 | 48,603,365.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 10,225,100.00 | 5,422,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,800,000.00 | 43,181,365.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 2,158,400.00 | 3,896,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,158,400.00 | 3,896,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 5,203,104.00 | 5,914,377.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 4,915,200.00 | 5,129,977.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 0.00 | 72,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 58,000.00 | 57,600.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 119,820.00 | 120,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 35,000.00 | 49,300.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 0.00 | 445,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 40,500.00 | 40,500.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 34,584.00 | 0.0 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 8,053,618.00 | 13,382,154.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 8,053,618.00 | 13,382,154.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **47,238,800.00** | **1,287,642.80** |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 46,238,800.00 | 0.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,000,000.00 | 0.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 0.00 | 1,287,642.80 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **32,384,182.00** | **190,737,357.58** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **12,764,900.00** | **95,455,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **12,764,900.00** | **95,455,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 12,764,900.00 | 95,455,000.00 |
| 222001 | Тоног төхөөрөмж | 11,414,900.00 | 95,455,000.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 1,350,000.00 | 0.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(12,764,900.00)** | **(95,455,000.00)** |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | 0.00 | 0.00 |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 19,619,282.00 | 95,282,357.58 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 0.00 | 19,619,282.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 19,619,282.00 | 114,901,639.58 |

### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*Тайлант хугацаа: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан*

*/төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 207,097,069.44 | 87,342,690.90 | 267,602,265.27 | 562,042,025.61 |
| C03 | **Дахин илэрхийлсэн** | **207,097,069.44** | **87,342,690.90** | **267,602,265.27** | 562,042,025.61 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | **үлдэгдэл** | | | | |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | (10,837,966.04) | (10,837,966.04) |
| C08 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **207,097,069.44** | **87,342,690.90** | **256,764,299.23** | 551,204,059.57 |
| D01 | **2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **307,097,069.44** | **87,342,690.90** | **564,607,307.71** | 959,047,068.05 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **207,097,069.44** | **87,342,690.90** | **256,764,299.23** | 551,204,059.57 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 79,852,799.87 | 79,852,799.87 |
| D09 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **307,097,069.44** | **87,342,690.90** | **644,460,107.58** | 1,038,899,867.92 |

### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*Тайлант хугацаа: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан*

*/төгрөгөөр/*

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | Хувь |
|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **0.00** | **0.00** | **0.0** |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **850,496,600.00** | **766,193,017.42** | **90.1** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **850,496,600.00** | **670,738,017.42** | **78.9** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **850,496,600.00** | **669,450,374.62** | **78.7** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **408,244,400.00** | **390,224,563.15** | **95.6** |
| 210101 | Үндсэн цалин | 247,769,100.00 | 254,409,242.60 | 102.7 |
| 210102 | Нэмэгдэл | 127,227,900.00 | 106,386,301.10 | 83.6 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 5,775,000.00 | 4,640,996.45 | 80.4 |
| 210104 | Урамшуулал | 27,472,400.00 | 24,788,023.00 | 90.2 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **51,530,400.00** | **45,910,608.67** | **89.1** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 35,040,700.00 | 32,958,654.57 | 94.1 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,122,400.00 | 3,401,602.92 | 82.5 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,297,900.00 | 2,684,322.30 | 81.4 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 824,500.00 | 685,677.85 | 83.2 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,244,900.00 | 6,180,351.03 | 75.0 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **53,374,500.00** | **52,086,857.20** | **97.6** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,500,000.00 | 2,531,312.20 | 72.3 |
| 210302 | Түлш, халаалт | 49,574,500.00 | 49,555,545.00 | 100.0 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 300,000.00 | 0.00 | 0.0 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **46,791,300.00** | **33,954,771.60** | **72.6** |
| 210401 | Бичиг хэрэг | 3,839,600.00 | 3,335,530.00 | 86.9 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 29,742,900.00 | 25,495,686.00 | 85.7 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,586,400.00 | 1,444,595.60 | 91.1 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 5,122,400.00 | 1,105,660.00 | 21.6 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 6,500,000.00 | 2,573,300.00 | 39.6 |
| **2105** | **Нормативт зардал** | **133,320,800.00** | **75,477,678.00** | **56.6** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 116,713,600.00 | 61,200,978.00 | **52.4** |
| 210502 | Хоол, хүнс | 12,940,400.00 | 11,545,700.00 | 89.2 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 3,666,800.00 | 2,731,000.00 | 74.5 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **128,825,000.00** | **48,603,365.00** | **37.7** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 62,000,000.00 | 5,422,000.00 | 8.7 |
| 210604 | Урсгал засвар | 66,825,000.00 | 43,181,365.00 | 64.6 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **3,900,000.00** | **3,896,000.00** | **99.9** |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,900,000.00 | 3,896,000.00 | 99.9 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **7,179,300.00** | **5,914,377.00** | **82.4** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 5,094,000.00 | 5,129,977.00 | 100.7 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 432,000.00 | 72,000.00 | 16.7 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 57,600.00 | 57,600.00 | 100.0 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 120,000.00 | 120,000.00 | 100.0 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 34,800.00 | 49,300.00 | 141.7 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,350,000.00 | 445,000.00 | 33.0 |
| 210807 | Газрын төлбөр | 40,500.00 | 40,500.00 | 100.0 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 50,400.00 | 0.00 | 0.0 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **17,330,900.00** | **13,382,154.00** | **0.0** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 17,330,900.00 | 13,382,154.00 | 0.0 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **0.00** | **1,287,642.80** | **0.0** |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | **0.00** | **1,287,642.80** | **0.0** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 0.00 | 1,287,642.80 | 0.0 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **0.00** | **95,455,000.00** | **0.0** |
| 222001 | Тоног төхөөрөмж | 0.00 | 95,455,000.00 | 0.0 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **850,496,600.00** | **861,475,375.00** | **101.3** |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **270,952,000.00** | **57,372,834.00** | **21.2** |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 270,952,000.00 | 57,372,834.00 | 21.2 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **55,374,500.00** | **55,374,500.00** | 100.0 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 55,374,500.00 | 55,374,500.00 | 100.0 |
| **1340** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 524,170,100.00 | 570,092,241.00 | 108.8 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 524,170,100.00 | 570,092,241.00 | 108.8 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **0.00** | **178,635,800.00** | **0.0** |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 0.00 | 178,635,800.00 | 0.0 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **0.00** | **19,619,282.00** | **0.0** |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **0.00** | **114,901,639.58** | **0.0** |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баян-Агт сумын Эрүүл мэндийн төв нь 2022 онд аймгийн Эрүүл мэндийн газар болон Засаг даргатай Гүйцэтгэлийн төлөвлөгөөг 5 зорилтын хүрээнд 31 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, батлуулсныг 96 хувийн биелэлтэйгээр тайлагнажээ.

Улсын төсвөөс 796,581.1 мянган, орон нутгийн төсвөөс 64,859.3 мянган, нэмэлтээр 35.0 мянган төгрөгийн санхүүжилт авсан. 2021 онд төсвийн санхүүжилтийн дутуу 183,271.1 мянган төгрөгийн авлагатай байсан. Мөн “Нүүдлийн амбулатор”-ийн тусламж үйлчилгээ, эрт илрүүлэг үзлэг зохион байгуулсан байна.

Сүрьегүй сум болох, магадлан итгэмжлэл орж, амбулаторийн 2 дугаар байранд урсгал засвар хийж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангагджээ.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Эрүүл мэндийн төв нь Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон дараах бусад хууль, тогтоомжид нийцүүлэн чиг үүргээ хэрэгжүүлж байна.Үүнд:

- Төрийн хэмнэлтийн тухай хууль;
- Хөдөлмөрийн тухай хууль;
- Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоол “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай”;
- Засгийн газрын 2022 оны 194 дүгээр тогтоол “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”;
- Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоол “Автомашин ашиглалтын тухай”;
- Сангийн сайд, Монгол банкны Ерөнхийлөгчийн 2022 оны А122/А-172 дугаар хамтарсан тушаалын хавсралт “Засгийн газар болон төсвийн байгууллагын дансыг банканд нээх, хаах, тайлагнах журам”;
- Сангийн сайдын 2022 оны 120 дугаар тушаал “Албан томилолтын зардлын тариф шинэчлэн батлах тухай”,
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль;
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Төрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль;

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

2022 онд аймгийн Дотоод аудитын албанаас тус байгууллагын 2021 оны үйл ажиллагаанд аудит хийж илэрсэн зөрчлүүдэд өгсөн зарим зөвлөмжүүд 2022 оны санхүүгийн тайлан батагаажуулах аудитаар давтагдаж буй тул дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баян-Агт сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна. Санхүүгийн үйл ажиллагаандаа ашигладаг Си Ти Эс програм хангамж ашигладаг.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баян-Агт сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн ба тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 79,499.7 мянган төгрөг буюу 8.3 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 19,619.3 | 114,901.6 | 95,282.3 |
| Авлага | 187,351.0 | 132.5 | -187,218.5 |
| Бараа материал | 158,131.8 | 190,396.1 | 32,264.3 |
| Үндсэн хөрөнгө | 594,298.0 | 733,469.6 | 139,171.6 |
| **Нийт хөрөнгө** | **959,400.1** | **1,038,899.8** | **79,499.7** |
| Богино хугацаат өр төлбөр | 353.1 | 0.0 | -353.1 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 959,047.1 | 1,038,899.8 | 79,852.7 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **959,400.1** | **1,038,899.8** | **79,499.7** |

Хүснэгт дэх 2022 оны мэдээллийг өмнөх оны үзүүлэлттэй харьцуулж гарсан өөрчлөлтийг судлан үзэхэд Эрүүл мэндийн даатгалын сангаас авсан санхүүжилт нь мөнгөн хөрөнгийг, бараа материалын өсөлт хандив буюу үнэгүй авсан эм, боох материал 74,423.2 мянган, тусгай зориулалтын 74.2 мянган, туслах аж ахуйгаас мах 192.0 мянган нийт 74,689.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь, үндсэн хөрөнгө барилга байгууламж, орон сууц 12,300.0 мянган, тээврийн хэрэгсэл 5,000,0 мянган, машин тоног төхөөрөмж 41,922.6 мянган, тавилга эд хогшил 292.6 мянган, мөн 37,900.0 мянган төгрөгийн шилжиж ирсэн тээврийн хэрэгсэл нийт 97,415.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь өсөлтөд нөлөөлсөн байна.

Өнгөрсөн оны эмийн өр төлбөрийг бүрэн барагдуулж, авлагаа бууруулж, 2022 оны эцэст анх хэзээ хэрхэн үүсэн нь тодорхойгүй 132.5 мянган төгрөгийн авлага үлдэгдлээр бүртгэгдсэн.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 619,797.2 мянган, орон нутгийн төсвөөс 64.594.5 мянган, эрүүл мэндийн сангаас 32,100.0 мянган төгрөг нийт зарлагыг 716,491.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

2022 оны төсвийн төслийг 134,005.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж төсвийг 850,496.6 мянган төгрөгөөр баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх арга хэмжээг санхүүжүүлэхээр батлагдсан 850,496,6 мянган төгрөгийн төсөв 94.1 хувийн гүйцэтгэлтэй байна.Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Тайлант онд нэмэлт санхүүжилт аваагүй.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баян-Агт сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах Төсвийг зохистой удирдаж, зориулалтын дагуу зарцуулах, эд хариуцагчтай хөдөлмөрийн гэрээ байгуулах талаар болон Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой өгсөн зөвлөлүүдийг тусгасан болно.

Баян-Агт сумын Эрүүл мэндийн төв 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баталгаат тооцоолол аудит ХХК-д 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр ирүүлсэн.

Аудитыг Баталгаат тооцоолол аудит ХХК-ийн аудитор Н.Цэнгэнбаяр, дотоод хяналтыг аудитын менежер Г.Батбаяр гүйцэтгэж, захирал М.Буянбулган нар хянан удирдаж, аудитын ажлын үе шатны болон гол хяналтуудыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Ж.Энхцоодол, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар хэрэгжүүлэв. .

**4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд байгууллагын орлогын эх үүсвэр нь улсын төсөв болон үндсэн үйл ажиллагааны орлогоос бүрддэг тул 2022 оны батлагдсан төсвийн нийт орлогыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тооцож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны батлагдсан төсвийн нийт орлогын 383,920.6 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 3,839,2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоосон.

**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тухайн байгууллага 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.2, 12.1.3 дахь заалтууд, 15 дугаар зүйлийн 15.1.2-15.1.7 дахь заалтуудад заасан хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй байна.

Энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан дэд дарга, орлогч дарга, 6 дугаар зүйлд заасан тээврийн хэрэгсэл, 7 дугаар зүйлд заасан албан тасалгаа, 8 дугаар зүйлд заасан албан тасалгаа, 10 дугаар зүйлд заасан цалин хөлс, нэмэгдэлтэй холбоотой заалтууд хамаарахгүй байна.

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор цалин хөлс болон нэмэгдэл урамшил 18,019.8 мянган, тогтмол зардлыг 1,287.6 мянган, хангамж, бараа материалын зардал 12,836.5 мянган, нормативт зардал 57,843.1 мянган, эд хогшил, урсгал засварын зардал 80,221.6 мянган, бараа үйлчилгээний бусад зардал 3,948.7, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйчилгээний зардлыг 8,088.7 мянган төгрөгөөр хэмнэж ажилласан байна.

**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

2022 онд нийт 148 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас мэдээллүүдийг оруулснаар байршуулсан. Тулган шалгахад 2 нь хугацаа болоогүй, мэдээлэлгүй 13, хугацаа хоцроосон 12, төсөв, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой эрхлэгчийн 2022 оны 3-н А, 24-н Б тушаалыг тусгаагүй. Үүнд: Нийт 14,782.2 мянган төгрөгийн 12, мөнгөн дүнгүй 15 тушаал байна.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Аудитын байгууллагын сонгон шалгаруулалтын хугацаанаас хамаарч завсрын аудит хийх боломжгүйд хүргэсэн. Аудитын нээлтийг 2022 оны 12 дугаар сарын 8-ны өдрийн 10 цагаас цахимаар эхлүүлж, аудит хийх мэдэгдэл, аудитад ирүүлэх баримтын мэдээллийн жагсаалтыг цахимаар болон биечлэн хүргүүлж, байгууллагуудын эхний хагас жилийн санхүүгийн тайланд судалгаа хийж, 2021 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан, өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт, байгууллагын талаарх мэдээлэлтэй танилцан аудитын төлөвлөлтийн үе шатны ажлыг гүйцэтгэв.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж, биелэлтийг 6 сард Булган аймаг дахь ТАГ-т хүргүүлжээ.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Албан шаардлага | 5 | 6,762.8 | 5 | 6,762.8 | 100.0 |
| Зөвлөмж | 3 | 12,050.6 | 3 | 12,050.6 | 100.0 |
| Залруулга | 4 | 29,512.6 | 4 | 29,512.6 | 100.0 |
| **Нийт дүн** | **12** | **48,326.0** | **12** | **48,326.0** | 100.0 |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитаар илэрсэн зөвлөмж болон хүргүүлсэн асуудлуудын хэрэгжилтийг завсрын аудитыг гүйцэхэд анхаарна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар батламж мэдэгдлийн хүрээнд нийт 204,551.5 мянган төгрөгийн алдаа[1] илэрснээс аудитын явцад 179,055.8 мянган төгрөгийн алдааг залруулж, эрх зүйн акт зөрчигдсөн[2] 4 алдааг дахин давтан гаргахгүй байх 1 зөвлөмж, 3 албан шаардлага өгөхөөр аудитын баг шийдвэрлэв.

### 5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй.

### 5.2 Албан шаардлага

Аудитаар 3 албан шаардлага өгөв.

### 5.3 Зөвлөмж

#### 1. Ажил гүйлгээний ангитай холбоотой асуудал

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл

***Илрүүлэлт:*** 420.0 мянган төгрөгийн мал амьтдыг хүнсний материалд, 178,055.8 мянган төгрөгийн урсгал санхүүжилтыг давхар бичилт хийсэн. Энэ нь санхүүгийн тайлангийн эдийн засгийн ангилал буруу илэрхийлэгдэх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4-д: *Үнэн зөв байх*, 15.1-д*: Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна*, 15.2-т: *Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна,* 20.2.4-т: *Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх* гэсэн заалттай нийцэхгүй байна.

***Өгсөн зөвлөмж:*** Санхүүгийн тайланг эдийн засгийн зөв ангиллын дагуу бүртгэж, илэрхийлэх, гүйцэтгэлд тавих хяналтаа сайжруулах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 6 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Залруулга | 1 | 179,055.8 | | | 1 | 179,055.8 | 1 | 179,055.8 | | | 1 | 179,055.8 |
| Дүн | 1 | 179,055.8 | | | 1 | 179,055.8 | 1 | 179,055.8 | | | 1 | 179,055.8 |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Эрх зүйн актыг мөрдөөгүй | 3 | 40,410.4 | | | 3 | 40,410.4 | | | | | | |
| Дүн | 3 | 40,410.4 | | | 3 | 40,410.4 | | | | | | |